



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/837.

Булган сум

Шагнаж, урамшуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.1.3, 2023 оны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны ахмад настнуудын нийгмийн хамгааллыг сайжруулж, хөгжил оролцоог нэмэгдүүлэхэд идэвх зүтгэл гарган, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлан ажилласан “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-г шагнасугай.

2.Аймгийн “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-г шагнахад шаардагдах 698,000 (Зургаан зуун ерэн найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн “Тэргүүний ахмад”, “Ахмадад ээлтэй байгууллага”, “Шилдэг ахмадын хороо”-оор шалгарсан ахмад настан, байгууллага хамт олныг шагнах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010989

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын
15 өдрийн А/Б/Г дугаар захирамжийн хавсралт



Аймгийн “Тэргүүний ахмад”, “Шилдэг ахмадын хороо”,
“Ахмадад ээлтэй байгууллага”-аар шалгарсан иргэн,
байгууллага хамт олонд олгох шагнал, урамшуулал

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн төсөв	Нийт төсөв
1.	2023 оны тэргүүний ахмад настан Ж.Рина	1 хүн	100,000	100,000
2.	Ахмадад ээлтэй байгууллагаар шалгарсан	3 байгууллага	100,000	300,000
	- Сэлэнгэ сумын ЗДТГ, - Хишиг-Өндөр сумын ЭМТ - Хутаг-Өндөр сумын “Занадуразорбак” ХХК			
	Аймгийн шилдэг ахмадын хороо - Бугат сумын Ахмадын хороо	1 байгууллага	150,000	150,000
3.	Өргөмжлөл, жаазтай	A4-1	20,000	20,000
		A3-4	32,000	128,000
Нийт дүн			698,000	

-----oOo-----